



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 02 сарын 28 өдөр


Дугаар А/09

Өлгий

**Г Сургалт, хөгжлийн төлөвлөгөө батлах тухай**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67-р зүйлийн 67.5 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/39 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны сургалт, хөгжлийн төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, хуулийн асуудал хариуцан мэргэжилтэн /Х.Айнур/-т даалгасугай.

ДАРГА  К.БОЛАТ

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны 22 дугаар сарын 28-ний өдрийн 22 дугаар тушаалын хавсралт

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРААС  
“ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛ”-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Жендерийн эрх тэгш байдлыг хангах хэрэгжүүлэх			Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Газрын харилцааны салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг		
Үр дүн			<p>1.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, газрын харилцааны салбарт Жендерийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.</p> <p>1.2 Салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн талаар баримтлах бодлого, бодлогын хэрэгжилтийн талаарх мэдлэг, арга замын талаарх ойлгоцыг бүх түвшинд түгээсэн байна.</p> <p>1.3 Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд болон иргэнийг ажил авахад нас, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө шинээ, газрын байршил болон бусад зүйлээр үл ялгаварлах, ажлын байранд бэлгийн дарамт шахалтүүсэхгүй байх зохицуулалт, нөхцөл бүрдэнэ.</p>		
Зорилт			<p>1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, газрын харилцааны салбарт Жендерийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах.</p> <p>2. Салбарын ажилтнуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендерийн мэдрэмжтэй бодлого үйл ажиллагаагаар мэдлэг, судалгаа, мэдээлэлд суурилан хэрэгжүүлэх.</p>		
Үйл ажиллагаа		Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1: Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Жендерийн үндэсний хорооноос гарсан шийдвэр, газрын харилцааны салбарт Жендерийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах					

<p>1.1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Газрын харилцааны салбарт Жендерийн талаар баримтлах талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлд төр, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<p>Газрын харилцааны салбарт Жендерийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэг зөвлөгөөнд хамрагдсан байна.</p>	<p>ШҮ1: Хэлэлцүүлэг-1 ШҮ2: Хэрэгжилтийн чиглэлээр авч сайжруулах хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн ШҮ3: Сургалт сурталчилгааны ажлын тоо</p>	<p>II-IV улиралд</p>	<p>ГХБХБГ</p>
<p>1.2. Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн газар тайланд өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын талаарх бүх мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргаж, мэдээллийг бүрдүүлэх</p>	<p>1. Газрын нэгдмэл сан болон салбарын хүний нөөцийн мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргадаг болсон байна. 2. Салбарын үйл ажиллагааг жендерийн мэдрэмжтэй төлөвлөхөд суурь судалгаатай болсон байна.</p>	<p>ШҮ1: Мэдээлэлд хамрагдахтын тоо ШҮ2: Хэрэгжилтийн хувь</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>1.3. Салбарын чиглэлээр төсөл хөтөлбөр, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд болон байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бүлгийн оролцоотой хэлэлцэн, шийдвэрлэж байх.</p>	<p>1. төсөл хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоог хангах, тэдний хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. 2. Байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний санал, бодлыг сонссон байна.</p>	<p>ШҮ1: Үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн тоо, тэдний хүйсийн харьцаа ШҮ2: Ажлын үр дүн</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>1.4. Салбарын мэргэжилтнүүд инженер техникийн болон бусад ажилтнуудад жендерийн эрх тэгш байдал, мэдлэг олгох ажлыг Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.</p>	<p>1. Жендерийн эрх тэгш, тал тод байдал хангагдсан байна.</p>	<p>ШҮ1: Сургалтын хөтөлбөрт тусгагдсан заалт хэрэгжсэн байх ШҮ2: Хэрэгжилтийн хувь</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>

<p>1.5. Жендерийн Үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад байгууллага, мэргэжлийн байгууллага, ТББ-ын удирдлагуудыг хамруулах арга хэмжээ авах.</p>	<p>1. Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон сонирхсон албан хаагчдын энэ талын мэдлэг дээшилсэн байна. 2. Сургагч багш нартай болсон байна.</p>	<p>ШҮ1: Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>1.6. Байгууллагын удирдах ажилтнууд болон албан хаагчдыг жендер, хүний эрхийг хангах чиглэлээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>1. Ажилтнууд жендерийн эрх тэгш байдал, түүнийг хэрэгжүүлэх талаар мэдлэг, аргачлал эзэмшиж, хэрэглэх чадамжтай болсон байна.</p>	<p>ШҮ1: Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>1.7. Байгууллагын удирдах ажилтнууд болон албан хаагчдыг жендер, хүний эрхийг хангах чиглэлээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>1. Ажилтнууд жендерийн эрх тэгш байдал, түүнийг хэрэгжүүлэх талаар мэдлэг, аргачлал эзэмшиж, хэрэглэх чадамжтай болсон байна.</p>	<p>ШҮ1: Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>Үйл ажиллагаа</p>		<p>Бүтээгдэхүүн</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>	<p>Хамтран хэрэгжүүлэх байгууллага</p>
<p><b>Зорилт 2: Салбарын албан хаагчдын зохистой хөдөлмөр эрхлэлт, харилцааг эрх тэгш байдлын үндсэн дээр жендерийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх</b></p>				
<p>2.1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах чиглэлээр байгууллагын албан хаагчдын дунд санал асуулга явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, холбогдох арга хэмжээ авч байх, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх.</p>	<p>1. Санал асуулга-23 2. Ажилтнуудаа шинжилгээ, оношилгоо, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. 3. Байгууллагын албан хаагчдын нас хүйс, албан тушаал, цалин, чөлөө, нийгмийн аталгааны чиглэлээрх мэдээлэл бүхий судалгааг харьцуулан гаргаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ШҮ1: Асуулга явуулсан байгууллагын тоо ШҮ2: Шинжилгээ, оношилгоонд хамруулсан албан хаагчдын тоо ШҮ3: Судалгаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
<p>2.2 Иргэн ба албан хаагчдыг ажилд авах болон хүний нөөцийн асуудлаар ялгаваралгүйгээр шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, шударга, хувь хүнтэй зөвшилцлийн замаар шийдвэрлэх нөлөөллийг бий болгох арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх.</p>	<p>1. Хүний нөөцийн талаар гарсан шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна. 2. Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албанд жендерийн тэгш байдлын баталгааг хангасан байна.</p>	<p>ШҮ1: Шийдвэр хууль тогтоомжийн дагуу гарсан байна. ШҮ2: Хүний нөөцийн талаарх шийдвэртэй холбогдон гарсан гомдол, саналын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>

<p>2.3. Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн харилцааг жөндөрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдөх, урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулан бэлгийн дарамт болон бусад шахалт дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх.</p>	<p>1. Хөдөлмөрийн харилцаа, тэгш зарчмаар явагдсан байна. 2. Ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн болон бусад дарамт шахалт гарахгүй байна. 3. Гарсан зөрчлийг үл тэвших оршин бүрдсэн байна.</p>	<p>ШҮ1: Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. ШҮ2: Зохион байгуулсан ажлын тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>ГХБХБГ</p>
--	---	--	---------------	---------------

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар